



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАНДАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.08.04 № 05/7178
танай 2018.08.29-ны № 01/2889.01/2928

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай


Татварын ерөнхий газрын Татварын удирдлага хамтын ажиллагааны татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Дандарын Энхтуяа, татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Лхагвасүрэнгийн Мөнхтуул, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасагт татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Баттөрийн Ганбаяр, Хувь хүний татварын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Шараагийн Отгонтуяа, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасагт татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Наранбаярын Ганчимэг, Төв аймгийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасагт татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Дашдаваагийн Чулуунхүү нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан бусад хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигчид нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.-т заасны дагуу 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ОРЛОГЧ БӨГӨӨД
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Л.СҮХ-ОЧИР



0012106